



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/16/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Сарансүх
Утас: 261665 Цахим хаяг: saransukhya@audit.gov.mn
Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@aaudit.gov.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	11
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	11
3.5.3 Нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.7.1 Завсрын аудитын талаар	14
4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил	16
5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил	16
5.2.1 Албан шаардлага	16
5.2.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.БАДРАХБАЯР ТАНАА

2023.03.04 № 01/670
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 795.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” тогтоолын хүрээнд “Оролцоо” төслийг хэрэгжүүлэхээр 11,099.0 сая төгрөгийг тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөн, 2,931.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Анод банк 2005 онд актив хөрөнгөгүй болж, татан буугдах болсонтой холбоотойгоор ХЭДС-аас ажлын байр бий болгох жижиг зээлийн эх үүсвэрийг дамжуулан зээлдэх гэрээгээр тус банканд байршуулсан 800.0 сая төгрөгийг барагдуулах боломжгүй болсон тул Анод банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн 2015 оны 110 дугаар

Z:\Yawsan_Bichig\2023\0324 SNAG-2.Docx

0001051310

тушаалаар алдагдалд хаах шийдвэрийг гаргасан боловч дээд шатны байгууллагууд уг асуудлыг шийдвэрлээгүй байна. Мөн Санхүүгийн тайланд он дамжсан насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан Капитал банкнаас авах 3,865.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 97.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт үүнд хамааралгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,400,068,381.56	183,834,931,606.68
33	АВЛАГА	161,339,932,796.56	183,833,771,606.68
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	48,000.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	87,318,181,386.92	73,299,301,594.91
33400	Зээлийн хүүгийн авлага	207,471,324.18	95,794,283.14
33500	Бусад авлага	4,155,706,161.53	5,419,581,731.75
33510	Байгууллагаас авах авлага	3,019,990,797.00	5,376,821,371.66
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,135,715,364.53	42,760,360.09
33600	Зээлийн авлага	69,658,525,923.93	105,019,093,996.88
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	59,434,025,923.93	95,340,313,996.88
33612	Хувь хүмүүст олгосон зээл	42,542,236,707.36	58,792,364,251.31
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	16,891,789,216.57	36,547,949,745.57
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	10,224,500,000.00	9,678,780,000.00
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	10,224,500,000.00	9,678,780,000.00
34	УРЬДЧИЛГАА	54,653,085.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	54,653,085.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	5,482,500.00	1,160,000.00
35400	Хангамжийн материал	5,482,500.00	1,160,000.00
35410	Бичиг хэргийн материал	-	900,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,330,000.00	260,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,152,500.00	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	161,400,068,381.56	183,834,931,606.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,747,873,521.61	30,840,995,831.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,958,678,521.00	19,147,548,004.00
41300	Өглөг	23,459,521.00	24,651,004.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,027,921.00	60,000.00
41360	Бусад өглөг	22,431,600.00	24,591,004.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,595,600.00	23,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,836,000.00	1,591,004.00
41400	Урьдчилж орсон орлого	19,935,219,000.00	19,122,897,000.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	19,935,219,000.00	19,122,897,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,789,195,000.61	11,693,447,827.34
42200	Урт хугацаат зээл	10,789,195,000.61	11,693,447,827.34
42210	Төгрөг	10,789,195,000.61	11,693,447,827.34
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	10,789,195,000.61	11,693,447,827.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	130,652,194,859.95	152,993,935,775.34
51	Засгийн газрын хувь оролцоо	130,652,194,859.95	152,993,935,775.34
51200	Хуримтлагдсан үр дүн	130,652,194,859.95	152,993,935,775.34
51210	Өмнөх үеийн үр дүн	156,420,846,197.74	130,619,798,180.95
51220	Тайлант үеийн үр дүн	(25,768,651,337.79)	22,374,137,594.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	161,400,068,381.56	183,834,931,606.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	53,738,167,844.62	49,522,789,460.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,654,820,244.62	49,187,464,460.23
120	Нийтлэг татварын бус орлого	53,654,820,244.62	49,187,464,460.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,232,040,309.89	49,187,464,460.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,263,591,941.55	44,378,620,433.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,615,077,030.89	4,808,844,026.37
1200046	Зээлийн хүүгийн орлого	353,371,337.45	-
120009	Бусад орлого	422,779,934.73	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,347,600.00	335,325,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,347,600.00	335,325,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43,457,350.00	231,325,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,890,250.00	104,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	79,509,571,160.97	25,062,391,039.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,509,571,160.97	25,062,391,039.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,043,147.00	360,488,516.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,000,000.00	-
210404	Ном, хэвлэл	10,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,887,665.00	185,630,485.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,352,092.00	185,630,485.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	45,535,573.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	749,155,482.00	174,858,031.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	431,307,382.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	317,848,100.00	174,858,031.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,404,528,013.97	24,701,902,523.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,993,018,079.24	24,238,777,563.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,993,018,079.24	24,238,777,563.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	983,275.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,275.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	972,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,097,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,097,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	407,412,934.73	462,141,685.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	403,972,934.73	462,141,685.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	3,440,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(25,771,403,316.35)	24,460,398,421.12
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,751,978.56	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,751,978.56	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,086,260,826.73
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	2,086,260,826.73
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(25,768,651,337.79)	22,374,137,594.39

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	175,400,610,249.80	112,925,605,389.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,422,676,430.97	97,017,712,524.81
120	Нийтлэг татварын бус орлого	145,422,676,430.97	97,017,712,524.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,422,676,430.97	97,017,712,524.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,297,676,655.83	41,248,476,436.89
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,458,705,246.29	4,825,286,027.42
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	92,666,294,528.85	50,943,950,060.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,977,933,818.83	15,907,892,864.49
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	28,294,435,319.65	14,176,706,051.49
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	28,294,435,319.65	14,176,706,051.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,683,498,499.18	1,731,186,813.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,273,794,140.00	686,861,685.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,890,250.00	104,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	357,814,109.18	940,325,128.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,000,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,400,610,249.80	92,925,605,389.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,400,610,249.80	92,925,605,389.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	979,303,747.00	299,566,736.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	220,624,115.00	124,708,705.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,938,542.00	124,708,705.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	47,685,573.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	758,679,632.00	174,858,031.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	439,381,432.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	319,298,200.00	174,858,031.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,421,306,502.80	92,626,038,653.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,099,685,115.88	54,779,806,739.81
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,099,685,115.88	54,779,806,739.81
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	87,318,181,386.92	37,384,090,228.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,957,565,193.57	36,393,903,131.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,360,616,193.35	990,187,097.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,440,000.00	462,141,685.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	462,141,685.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	3,440,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	20,000,000,000.00

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(20,000,000,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	20,000,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	-	20,000,000,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	156,344,308,009.74	156,344,308,009.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	76,538,188.00	76,538,188.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	156,420,846,197.74	156,420,846,197.74
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,768,651,337.79)	(25,768,651,337.79)
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	130,652,194,859.95	130,652,194,859.95
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(32,396,679.00)	(32,396,679.00)
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	130,619,798,180.95	130,619,798,180.95
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
16	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
17	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
18	Тайлант үеийн үр дүн	-	-	22,374,137,594.39	22,374,137,594.39
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	152,993,935,775.34	152,993,935,775.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	102,886,079,900.00	73,860,190,316.81	29,025,889,583.19	71.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,886,079,900.00	53,860,190,316.81	29,025,889,583.19	65.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000,000.00	124,708,705.00	73,291,295.00	63.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000,000.00	124,708,705.00	73,291,295.00	63.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000,000.00	124,708,705.00	73,291,295.00	63.0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан					
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,688,079,900.00	53,735,481,611.81	28,952,598,288.19	65.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,688,079,900.00	53,735,481,611.81	28,952,598,288.19	65.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,688,079,900.00	53,735,481,611.81	28,952,598,288.19	65.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000,000,000.00	20,000,000,000.00	-	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	20,000,000,000.00	20,000,000,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	102,886,079,900.00	111,194,418,576.30	(8,308,338,676.30)	108.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	95,286,079,900.00	97,017,712,524.81	(1,731,632,624.81)	101.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,156,200,000.00	41,248,476,436.89	2,907,723,563.11	93.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,487,145,700.00	4,825,286,027.42	(2,338,140,327.42)	194.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	48,642,734,200.00	50,943,950,060.50	(2,301,215,860.50)	104.7
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	7,600,000,000.00	14,176,706,051.49	(6,576,706,051.49)	186.5
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	7,600,000,000.00	14,176,706,051.49	(6,576,706,051.49)	186.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,731,186,813.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,731,186,813.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,858,031.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,858,031.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	174,858,031.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,556,328,782.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	104,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,452,328,782.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	462,141,685.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	990,187,097.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,731,186,813.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,731,186,813.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	686,861,685.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	940,325,128.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны стратегийн мөн чанарыг “Хүн амын хөгжлийг хангах таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг, ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллагын тэргүүлэх чиглэл нь:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшнийг бууруулах;
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дэвшүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх;
- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сан нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын байдлын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай зэрэг хуулиуд болон бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХХҮЕГ-ын даргын 2020 оны А/154 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж, дээрх баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,434.9 сая төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	161,339,932.8	183,833,771.6	22,493,838.8
Бараа материал	5,482.5	1,160.0	(4,322.5)
Урьдчилж гарсан зардал	54,653.1	-	(54,653.1)
Нийт хөрөнгө	161,400,068.4	183,834,931.6	22,434,863.2
Өр төлбөр	30,747,873.5	30,840,995.8	93,122.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	130,652,194.9	152,993,935.8	22,341,740.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	161,400,068.4	183,834,931.6	22,434,863.2

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 183,833.7 сая төгрөг болж, өмнөх оноос 22,493.8 сая төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/213 дугаар тушаалын дагуу Хаан банканд 3,350.0 сая, Төрийн банканд 13,350.0 сая, Худалдаа хөгжлийн банканд 3,300.0 сая, нийт 20,000.0 сая төгрөгийн эх үүсвэрийг олгосон нь голлон нөлөөлсөн байна. Авлагын дансны үлдэгдэлд татаас санхүүжилтийн 73,299.3 сая, зээл, зээлийн хүүгийн авлага 46,322.5 сая, хөтөлбөртэй холбоотой 58,792.4 сая, бусад байгууллага, хувь хүнээс авах 5,419.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус бүртгэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэлд Налайх дүүргийн ХЭДС-ийн бичиг хэрэг, түлш, шатах тослох материалын 1.1 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 93.1 сая төгрөгөөр өссөн нь Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хооронд “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээл”-ийн эх үүсвэрийг дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан ба гэрээний дагуу Сангийн яамнаас ХНХЯ-аар дамжуулан ХХҮЕГ-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн зориулалтаар ашиглах 3,786,333.6 ам.долларыг 2 хувийн хүүтэй зээлээр олгож, эргэн төлөлтийг ам.доллаароор Монголбанкны тухайн өдрийн ханшаар төлөхөөр гэрээнд заасан байна. Тайлант онд валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдсэн байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 22,341.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 22,374.1 сая төгрөгөөр нэмэгдэж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 32.4 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Дорноговь аймгийн ХЭДС 379 иргэнээс авах 1,157.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй,
- Хан Уул дүүргийн ХЭДС 111.0 сая, Баянзүрх дүүргийн ХЭДС 12.8 сая, Сүхбаатар дүүргийн ХЭДС 203.1 сая, Налайх дүүргийн ХЭДС 212.4 нийт 539.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 131,534.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналыг 28,648.0 сая төгрөгөөр бууруулж, 74,238.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны тодотгосон төсвөөр төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 102,886.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, нийт зарлагын эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос 41,248.5 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 4,825.3 сая, урьд оны үлдэгдлээс 50,943.9 сая, дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэж төлөгдөх төлбөрөөс 5,868.3 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 73,861.7 сая төгрөг буюу 71.8 хувьтай байгаа нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 28,953.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 71.0 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2022 оны зорилтот түвшин		2022 оны хүрсэн түвшин		Хувь
		Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	
1	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	90,000	1,600,000.0	125,079	1,185,385.2	74.0
2	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	20,217	2,106,000.0	16,018	1,384,818.5	65.7
3	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	14,501	27,360,488.0	11,869	21,345,691.9	78.0
4	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	30,106	2,181,000.0	24,353	1,247,093.7	57.2
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5,090	11,768,600.0	4,427	9,557,646.4	81.2
6	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2,042	6,094,560.0	2,250	5,463,126.9	89.6
7	Ногоон ажлын байр хөтөлбөр	22,000	8,800,000.0	22,888	7,149,021.6	81.2
8	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2,185	1,395,870.0	3,482	618,228.3	44.3
9	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйл ажиллагаа		21,381,482.0		5,783,748.6	27.0
10	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих		198,000.0		126,958.7	64.1
11	Дотоод эх үүсвэрээс олгох зээл		20,000,000.0		20,000,000.0	100
НИЙТ		186,141	102,886,000.0	210,366	73,861,719.8	71.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 686.8 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 104.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 940.3 сая төгрөг нийт 1,731.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 174.8 сая, урсгал шилжүүлэг 1,556.3 сая төгрөг нийт 1,731.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бараа материал, дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн нэгдсэн зөвлөмжөөр хангаж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор Г.Мөнхчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ч.Болд, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/245 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 79,509.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 795.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ХХҮЕГ-ын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар харьяа газар, хэлтсийн алба хаагчдад "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих талаарх мэдээлэл өгөх, санал солилцох хэлэлцүүлэг"-ийг танхимаар зохион байгуулж, тус сангаас 24.0 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, зардлыг хэмнэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн оруулсан байна.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 17,961.2 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,438.6 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 7,522.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ХХААХҮЯ-ны Оёдлын холбоонд 2013 онд олгосон зээлийг эргэн төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан бөгөөд 14,447.9 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмын 6.7-д “Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасан талуудын хүлээх үүргийн дагуу шүүхийн шийдвэр гарсан авлагыг барагдуулах арга хэмжээг холбогдох газартай хамтран хэрэгжүүлэх талаар албан шаардлага өгөв.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийх завсрын аудитын хугацаанд байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван, эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 15,279.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 7.3 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	7	15,272,100.0	7	7,636,050.0	50.0
Зөвлөмж	1	7,100.0	1	7,100.0	100.0
Нийт дүн	8	15,279,200.0	8	7,643,150.0	75.0

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын явцад харьяа байгууллагуудын анхаарал татахуйц дараах асуудал байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/102 дугаар тушаалаар “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх” төслийг хэрэгжүүлэх хүрээнд багш, суралцагчдын хувьсах зардал, хөдөлмөр, хамгааллын тусгай хэрэгсэл худалдан авах 1,342.7 сая төгрөгийн арга хэмжээг зохион байгуулах эрхийг Батлан хамгаалахын сайдад шилжүүлсэн;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөтөлбөрт тусгасан болон тус сангаар дамжин хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл, зарцуулалт, хүрсэн үр дүн, гадаадаас ажиллах хүч авах ажлын байрны төлбөрийн орлогын бүртгэл, тус орлогыг буцаан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

олгох зохицуулалт, сангаас олгож буй зээл олголт, зээлийн эргэн төлөлт, эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаандаа эргэн төлж буй эсэх, эдгээрт тавих хяналт зэрэг асуудлуудыг аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитад хамруулаагүй тул дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1,138.1 сая төгрөгийн 11 алдаа¹ илэрч аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 29,481.8 сая төгрөгийн 82 зөрчил² илэрснээс, 356.3 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 24,956.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 хариуцлага тооцох, 25 албан шаардлага хүргүүлж, 4,169.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 47 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 29,481.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 795.1 сая төгрөгөөс өндөр тул **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

5.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 34 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 24 байгууллагын санхүүгийн тайланд Зөрчилгүй, 8 байгууллагын санхүүгийн тайланд Хязгаарлалттай, 2 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 4,405.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,138.1 сая төгрөгийн алдааг залруулж, 356.3 сая төгрөгийн зөрчилд 8 акт тогтоож, 2,177.3 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, 733.4 сая төгрөгийн зөрчилд 43 зөвлөмж өгсөн байна.

5.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 26,214.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 22,779.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 3,435.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

1. Анод банк 2005 онд актив хөрөнгөгүй болж, татан буугдах болсонтой холбоотойгоор ХЭДС-аас ажлын байр бий болгох жижиг зээлийг дамжуулан зээлдэх гэрээгээр тус банканд байршуулсан 800.0 сая төгрөгийг барагдуулах боломжгүй болсон тул Анод банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн 2015 оны 110 дугаар тушаалаар алдагдалд хаах шийдвэрийг гаргасан байна. Дээрх авлагыг барагдуулах талаар Монголбанк, Сангийн яам, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй авлага дансанд үлдэгдлээр бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагын хэрэгжүүлэх", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх" гэх заасантай тус тус нийцээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ий бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллага ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Дээрх авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах албан албан шаардлага өгөв.

2. Санхүүгийн тайланд он дамжсан насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан, Капитал банкнаас авах 3,865.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна. Жижиг зээл, сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлтэй холбоотой авлагыг найдваргүй авлага болохоос өмнө барагдуулах арга хэмжээг авах шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эргэн төлөлт удааширсан авлагыг барагдуулах албан шаардлага өгөв.

3. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хөтөлбөрөөс санхүүжүүлсэн 18,113.6 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байгаа нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмын 6.7 "Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого төлөвлөснөөс 3,385.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын байрны төлбөрийн орлогыг биелүүлж ажиллах, үндэслэлтэй төлөвлөх, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХЭДС-ийн эх үүсвэрээр 50.5 сая төгрөгийн шатахуун худалдан авсныг бараа материалын тайланд орлогоор бүртгэхдээ нэр төрөл, шатахууны талоны дэвсгэртээр ангилаагүй, зарлагыг бодит гүйцэтгэл гарсан цаг хугацаагаар бус худалдан авалт хийсэн өдрөөр нэгтгэсэн дүнгээр шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль

тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түлш, шатах тослох материалыг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн тоо ширхэг, нэр төрлөөр нь ангилан бараа материалын орлогоор бүртгэж, бодит гүйцэтгэлээр нь зардалд хүлээн зөвшөөрч бүртгэх, материалын үлдэгдэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3. Харьяа байгууллагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 29,481.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 14 дүгээр зүйлийн 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 16.5.7 "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
A	B	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,064.0					1	1,064.0				
2	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	6,480.7					2	6,480.7				
3	Завхан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	790,097.2					1	790,097.2				
4	Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	18,239.6					1	18,239.6				
5	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	2,371.0					1	2,371.0				
6	Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	208,020.8					1	208,020.8				
7	БЗД-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,290.0					1	3,290.0				
8	ХУД-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	3,022.2					2	3,022.2				
9	ХНХСИ-институт	1	105,559.3					1	105,559.3				
	Дүн	11	1,138,144.8	0	0	0	0	11	1,138,144.8				

01
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ХЯЗГААРЛАЛТАЙ
 САНАЛ ДҮГНЭЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	B	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
1	Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	9	520,929.6	2	346,172.00			7	174,757.6						
2	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	9,000.0	1	3,600.00	2	5,400.0	1							
3	Говь-Алтай аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	23,218.5	1	3,583.90	1	19,634.6								
4	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	5	4,734.3					3	4,734.3	2					
5	Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,687.6					1	1,687.6						
6	Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	26,932.7			1	7,452.7	1	19,480.0						
7	Завхан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	50,951.0					4	50,951.0						
8	Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	858.0					2	858.0						
9	Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	176,344.9			1	111,703.6	3	64,641.3						

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	7,278.5						1	7,278.5			
11	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	127,202.9						1	127,202.9			
12	Ховд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	3,656.0	1	1,856.00				1	1,800.0			
13	Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	33,547.3	1	135.00				1	33,412.3			
14	Говьсүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	4,980.0	1	200.00	2	4,780.0						
15	Багануур дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	25,986.6						2	25,986.6			
16	Багахангай дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	108,514.2			1	66,903.0		1	41,611.2			
17	Баянгол дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	494,603.1			1	494,603.1		1				
18	БЗД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	16,832.0						2	16,832.0			
19	Налайх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	6	218,329.2	1	800.00	2	215,467.2		3	2,062.0			
20	СХД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	39,676.3						2	39,676.3			
21	СБД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	203,142.5			1	203,142.5						
22	ХУД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	114,347.9						2	114,347.9			
23	Чингэлтэй дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	721,002.6			1	721,002.6						

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

24	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	23,529.0		2	23,529.0							
25	ХНХСИНСТИТУТ	6	11,231.2		2	5,129.6	4	6,101.6					
26	ХБХХЕГазар	5	298,515.0		5	298,515.0							
27	ХХҮЕГазар	7	26,214,796.3		3	22,779,196.3	4	3,435,600.0					
	Дүн	82	29,481,827.2	8	356,346.90	25	24,956,459.2	47	4,169,021.1	2	0	0	0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянаан төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Албан шаардлага				Зөвлөмж	
		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	B	1	2	3	4	5	6	7	8						
1	Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	510.0	1	510.0	1									
2	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,058,841.8			1	3,058,841.8								
3	Өвөрхангай аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	938,025.8			1	938,025.8								
4	Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1							
5	Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	15,120.0					1						15,120.0	
6	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	91,868.0					1						91,868.0	
7	Увс аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,599,449.5					1						1,599,449.5	
8	Ховд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	5,800.0					1						5,800.0	
9	Хөвсгөл аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1							
10	Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	2,013,061.5					1	14,763.1					1,998,298.4	
11	Дархан -Уул аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	31,240.0					1	31,240.0						
12	Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1							
13	Багануур хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1							
14	Багахангай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	4,137,273.3					1	4,137,273.3						
15	Баянгол дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	17,822.0											17,822.0	
16	БЗД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-												
17	Налайх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,155,084.5			1				1,155,084.5					
18	СХД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,429,000.0											1,429,000.0	
19	СБД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,103,375.1					1		1,103,375.1					
20	ХУД-ийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	2,323,614.0											2,323,614.0	
21	Чингэлтэй дүүргийн аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	10,008.0											10,008.0	
22	ХНХСИИ институт	1	31,180.6					1							
23	ХБХХЕГазар	1	-					2							
24	ХХҮЕГазар	2	14,471,949.5					14							
	Дүн	28	32,433,223.6	1	510.0	14	24,910,553.1	13	7,522,160.5						





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ АН.19070044

Улаанбаатар хот

СНАГ-2023/16/М-СЭБ-ЭТГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анод банк 2005 онд актив хөрөнгөгүй болж, татан буугдах болсонтой холбоотойгоор ХЭДС-аас ажлын байр бий болгох жижиг зээлийг дамжуулан зээлдэх гэрээгээр тус банканд байршуулсан 800,000,000.00 төгрөгийг барагдуулах боломжгүй болсон тул Анод банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн 2015 оны 11 дугаар тушаалаар алдагдалд хаах шийдвэрийг гаргасан байна. Дээрх авлагыг барагдуулах талаар Монголбанк, Сангийн яам, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан боловч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй авлага дансанд үлдэгдлээр бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Ахлах нягтлан бодогч Б.Гулзат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264330

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-2.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 413/АДТ0044
СНМГ-2023/16/СТА-317С

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд он дамжсан насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан Капитал банкнаас авах 3,865,100,000.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна. Жижиг зээл, сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлтэй холбоотой авлагыг найдваргүй авлага болохоос өмнө барагдуулах арга хэмжээг авах шаардлагатай байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр уг хөрөнгийг нөхөн төлүүлэх, санхүүжилтийг зогсоох, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эргэн төлөлт удааширсан авлагыг барагдуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Ахлах нягтлан бодогч Б.Гулзат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Төрийн аудитын газрын 4 дүгээр байр,
Утас 51-264330

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-2.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 344/100170074

Улаанбаатар хот

СНАГ-2023/16/НА-СНА-ЭТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хөтөлбөрөөс санхүүжүүлсэн 18,113,616,500.00 төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмын 6.7 "Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эргэн төлөлт удааширсан авлагыг барагдуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Балрахбаяр, Ахлах нягтлан бодогч Б.Гулзат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 715/А0140024

Улаанбаатар хот

СНАГ - 2023/15/14 - СНА - 57С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХААХҮЯ-ны Оёдлын холбоонд 2013 онд олгосон зээлийг эргэн төлүүлэх шүүхийн шийдвэр гарсан боловч тайлант оны эцэст 14,382,200,000.00 төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмын 6.7-д "Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээнд заасан талуудын хүлээх үүргийн дагуу шүүхийн шийдвэр гарсан авлагыг барагдуулах арга хэмжээг холбогдох газартай хамтран хэрэгжүүлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Ахлах нягтлан бодогч Б.Гулзат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-2.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 119/2023-0074

Улаанбаатар хот

СНХТ - 2023/16/НД - БТТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар харьяа газар, хэлтсийн алба хаагчдад хэлэлцүүлгийг танхимаар зохион байгуулж, тус сангаас 23,999,800.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоолын 5.3 "бүх төрлийн сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, зардлыг хэмнэж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Бадрахбаяр, Ахлах нягтлан бодогч Б.Гулзат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
Г.МӨНХЧИМЭГ